



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Ц.СЭМЖИДДОРЖ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.07.31 № 1/518

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Цэен-Ойдовын Сэмжиддоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого,

5020749

төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Цэен-Ойдовын Сэмжиддорж (ВА63092119)-ийн Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Ц.Сэмжиддоржид

Хувийг: Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.АЛТАНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

АУДИТОР

Н.БАТЧИМЭГ

АУДИТОР

Д.ЦЭДЭВЦЭВЭЭН




## БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024-07-20

### Нэг. Гэр бүл нийгмийн хөгжил

- 1.1. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөри эрхлэлтийг дэмжинэ.
- 1.2. Хөдөөгийн болон гэр хорооллын иргэдэд хувийн орон сууцтай болох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ
- 1.3. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийхэд зөвлөмж өгөх, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдуулах арга хэмжээ авах
- 1.4. Ипотекийн зээлд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх
- 1.5. Өрх толгойлсон эх, эцэгт хүүхдийг эрсдлээс хамгаалах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөл бүхий тэтгэлэгт хамруулах
- 1.6. Гэр бүлийн боловсрол олгох, “Монгол гэр бүл” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- 1.7. Хүүхдийг цахим хадлагаас хамгаалах орон нутгийн эрх зүйн орчин бүрдүүлэх
- 1.8. Хүүхдэд тулгач буй дээрэлхэлт, үе тэнгийнхний дарамт шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх нэгдсэн хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх
- 1.9. Залуучууд боловсрол эзэмшихэд нь туслах, тэднийг урамшуулах, дотоодын тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх
- 1.10. Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх орон нутгийн хөтөлбөр боловсруулж, өөрөө өөртөө ажлын байр бий болгох бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ
- 1.11. Залуучууд хөгжлийн төв байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлэх талаар үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана
- 1.12. Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих орон нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- 1.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг тэмжих бодлого хэрэгжүүлнэ.

0000001

- 1.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, тэднийг төрөл мэргэжилтэй болгох, мэргэшүүлэх, тэдний нийгмийн баталгааг дээшлүүлэх
- 1.15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлсэн үйлчилгээг нэвтрүүлэх

#### **Хоёр. Эрүүл мэнд**


- 2.1. Эрүүл мэндийг дэмжих тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана
- 2.2. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйл ажиллагааг сайжруулна
- 2.3. Эрүүл мэндийн салбарын эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчлэл, тоог нэмэгдүүлэх
- 2.4. Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах ажлыг орон нутгаас эхлүүлнэ

#### **Гурав. Боловсрол**

- 3.1. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ
- 3.2. Сургууль, цэцэрлэгийн мэргэшсэн багш ажилтны тоог нэмэгдүүлж, болосвролын зөвлөлийн оролцоог нэмэгдүүлнэ
- 3.3. Ерөнхий болосвролын сургалтын хөтөлбөрт тусгагдсан заавал судлан үзэх хичээлийн чанарыг дээшлүүлнэ
- 3.4. Хичээлээс гадуурх сургалт, дугуйланд хамрагдалтыг улсын дундажаас дээш байлгахад анхаарч ажиллана
- 3.5. Академик англи хэлний сургалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 3.6. Багш, суралцагсадын хөгжлийг дэмжих сургалтын цахим хөтөлбөр боловсруулж дэмжиж ажиллана

#### **Дөрөв. Эдийн засаг, ХАА-н салбар**

- 4.1. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ургацын талбайг нэмэгдүүлэх
- 4.2. ХАА-н үйлдвэрлэлийн болон газар тариалангийн кластр төслийг нээн хөгжүүлэх

0000002




- 4.3. Татвараа үнэн зөвөөр тодорхойлон ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх
- 4.4. Төрийн албанаас хувийн салбарт ажиллахыг дэмжсэн орон нутгийн эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох
- 4.5. Хөрөнгө оруулагчдыг дэмжих орон нутгийн хөтөлбөр боловсруулан ажиллана
- 4.6. Ноос боловсруулах, мах, түүхий эд бэлтгэх үйлдвэрийг нээн ажиллуулахад бизнес эрхлэгчдийн дэмжлэгийг хөхүүлэн дэмжих
- 4.7. Гэр хорооллыг дэд бүтэцтэй болгох

#### **Тав. Төр, захиргааны байгууллагын шинэчлэл**

- 5.1. Төрийн албан тушаалтан даргын эрх мэдлийг хамгаалсан төр захиргааны бодлогыг өөрчилж, иргэний эрхийг хамгаалсан, иргэдэд үйлчлэх хууль зүйн бодлоготой тамгын газрыг шинэчилнэ.
- 5.2. Авилга, албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг дэмжинэ.
- 5.3. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын иргэд өргөдлийн байнгын хороог шинэчилэн байгуулж, шууд ардчиллын хэлбэрээр хяналтын бүс байгуулах
- 5.4. Орон нутгийн Засаг захиргааны байгууллагыг цомхон, чадварлаг чанартай бүтэцтэй болгоход шинэчлэл хийнэ.
- 5.5. Олон нийтийн сүлжээнд иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байх, орон нутгийн засаг захиргааны бодлогыг дэвшүүлж хэрэгжүүлнэ
- 5.6. Гадаад бодлогыг улс төрчдөөс ангид, нэгдмэл байлгах төрийн нэгдсэн зарчмыг баримтлан төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын гадаад харилцааг дэмжин ажиллана
- 5.7. Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийн зураг төсвийг батлуулсантай холбогдуулан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллана

#### **Хөтөлбөр боловсруулсан:**

**Аймаг, орон нутгийн сонгуульд нэр дэвшихийг хүсэмжилсэн**



**Цэен-Ойдов овогтой Сэмжиддорж**

РД:BA63092119

Утас: 88929957

